

## **Монгол улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилд**

Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойтой холбогдуулан АНУ-ын Элчин сайдын яам, Мэдээллийн алба, Монголын зарим байгууллагатай хамтран хэд хэдэн арга хэмжээ зохиосны дотор “Америкийг хэн сайн мэдэх вэ?” гэсэн сэдэвт хүүхдийн зургийн уралдаан зохион байгуулж шалгаруулсанаас гадна Монголын урлагийн байгууллагын оролцоотойгоор 1997 оны нэгдүгээр сарын 25-ны өдөр Сонгодог Урлагийн Академик театрт концерт тоглуулж, түүнийхээ хөтөлбөрт Америкийн урлагийн бүтээлүүдээс оруулжээ.

АНУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойг хүндэтгэн Улаанбаатарт суугаа АНУ-ын Элчин Сайдын Яам 1997 оны нэгдүгээр сарын 27-нд хүлээн авалт хийж, түүнд Монгол Улсын УИХ-ын орлогч дарга Ц.Элбэгдорж, Монгол Улсын ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн П.Жасрай болон бусад зарим гишүүд, төр, засаг, нам, олон нийтийн зарим байгууллагын удирдах ажилтанууд, Монголд ажиллаж буй Америкийн зарим пүүс, компани, олон улсын байгууллагын төлөөлөгчид, түүнчлэн Улаанбаатарт суугаа гадаад орнуудын элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар уригдан оролцсон байна.

**Ойн хүлээн авалт дээр АНУ-ын хэргийг түр  
хамаарагч хатагтай Ллиуиллин Хэжбэтийн хэлсэн үг.**

Ноён Элбэгдорж, эрхэм сайдууд, Хүндэт зочид, Элчин сайдын Яамны ажилтанууд, Хатагтай, Ноёд нар аа!

АНУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойг тэмдэглэж хийж байгаа энэ арга хэмжээнд тавтай морилохыг урьж байна. Та бүхнийг хүрэлцэн

ирсэнд бид баяртай байгаа бөгөөд энэ нь магай хоёр орны харилцаа хэрхэн цэцэглэн хөгжиж байгаагийн нотолгоо мөн.

Өнөөдрийн энэ арга хэмжээнд оролцож чадаагүй бусад олон анд нөхөд бас бий. Тэдний дотор Төрийн нарийн бичгийн дарга асан Жэймс Бэйкер, хэдхэн сарын өмнө нутагтаа буцсан элчин сайд Дональд Жонсон, түүний гэргий Нэльда, элчин сайд Жо Лэйк, түүний гэргий Жоди болон Америкийн анхны элчин сайд Дик Уильямс нар зүй ёсоор орно. Хэрэв болдогсон бол тэд бүгд л энэ арга хэмжээнд оролцох ёстой юм.

Мөн өнөөдөр энд бидэнтэй хамт байхыг хүсч байгаа өөр хүмүүс гэвэл 1988 онд энд Элчин сайдын Яам нээгдсэнээс хойшхи хугацаанд ажиллаж байсан Америкийн дипломагууд байх нь мэдээж. Та нарын дотор олон хүн тэднийг санан дурсаж байгаа байх. Тэр үед Улаанбаатарг АНУ-ын ЭСЯ нээгдсэн гэдэгт үнэмшээгүй шуудангийн ажилтан манай ЭСЯ-нд ирсэн цахилгаан утсыг тэр үеийн зөвлөлтийн ЭСЯ-нд хүргэн өгч Зөвлөлтийн ЭСЯ-ны ажилтан уг цахилгааныг манай ЭСЯ-нд авчирч өгч байсан тухай та бүхний зарим нь ч сонссон байгаа. Урьд нь ажиллаж байсан хүмүүс хэрэв энэ орой энд байсан бол энэ арга хэмжээг хараад “бидний эхлэлийг нь тавилцаж байсан харилцаа ийм болжээ” хэмээн бахдан баярлах байсан болов уу.

Эдүгээ АНУ, Монгол улсын хоорондын хэлхээ холбоо олон салбарыг хамаарчээ. Өнөөдөр энэ танхимд цугларсан хүмүүсийг харахад л бид чинь хориодхон жилийн өмнө хэн хэнийхээ оршин тогтнодог эсэхийг ч бараг мэддэггүй байлаа шүү дээ гэдгийг төсөөлөхөд илүүдэхгүй. Хэрэв түүхийн үйл явдлууд та бүхний хүссэнээр өрнөсөн бол бид өнөөдөр 10 биш түүнээс илүү олон жилийнхээ ойг тэмдэглэж байж болох байсныг хэлэх хэрэгтэй. Ямар боловч сайшаалтай нь эдүгээ Монгол Улс нэгэнт хаалттай байгаа больж, хоёр орны иргэд харилцан зочилж, найрамдал хувь хүмүүсийн болон улсын хэмжээнд өргөжин батажсаар байна. Ингэснээр хоёр ард түмэн хэн хэн нь хожиж байна.

Энэ хугацаанд хоёр орны засгийн газар, улс төрийн удирдах олон хүн бие биэндээ харилцааг айлчилжээ.

Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд М.Энхсайхан, П.Жасрай, Д.Бямбасүрэн зэрэг Монголын зарим удирдагчид АНУ-д айлчилсан юм. Зөвхөн өнгөрсөн 18 сарын хугацаанд л гэхэд тэргүүн хатагтай Хиллари Клинтон, төрийн нарийн бичгийн дарга асан Жэймс Бэйкер, Конгрессын олон гишүүн зэрэг өндөр албан тушаалтан хүмүүс Монголд айлчилсныг үргэлжлүүлэн хэлж болно.

Хоёр орны эдийн засаг, худалдааны харилцаа ч нэгэн адил өргөжин тэлж байна. Монголд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын хэд хэдэн компаний төлөөлөгчид энд бидэнтэй хамт байна. Ингэснээр Монголын үйлдвэр, аж ахуйн хүрээнийхэн ч хамтын ажиллагаанд хамрагдаж байгаа. Манай “цөцгийн тосны сан” олон жижиг дунд аж ахуйн нэгжид хөл дээрээ зогсох боломж олгосон байна.

Ардчилал, зах зээлийн эдийн засаг руу тэмүүлж буй үед нь Монгол Улстай хамтран ажиллаж байгаадаа бид баяртай байдаг. Энэ салбарт чухал дэмжлэг үзүүлж байгаа АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн болон АНУ-ын санхүүжүүлж байгаа бусад сангийн ажилтнууд энд бидэнтэй хамт байна. Манай хоёр орны цэргийнхний нөхөрлөл, хамтын ажиллагааны үр дүнд хэд хэдэн хэсэгт хамтарсан сургалт зохион явуулж, хүнсний зүйл болон хувцас, хэрэглэл зэрэг хүмүүнлэгийн тусламжийг Монголд үзүүлэх боломжтой болов.

Хоёр орны соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт ч хамтын ажиллагаа нэн эрчимтэй өрнөж байна. Жилийн өмнө монголчууд интернетийн сүлжээнд холбогдох боломжтой болов. АНУ, Монголын музейн ажилтнууд АНУ-д “Монгол: Чингис Хааны өв” үзэсгэлэн зохион байгуулав. Энэ үзэсгэлэн үзсэн хүнийхээ тоогоор ч Америкчуудад алс холын Монголын тухай танилцуулснаараа ч ийм төрлийн бусад үзэсгэлэнгээс хол давж чадлаа. Америк болон Монголын эрдэм шинжилгээний хэдэн арван байгууллага, мэргэжилтнүүдийг улсын болон хувийн секторт харилцан илгээлээ. Энх Тайвны Корпусын сайн дурын 49 ажилтан эдүгээ Монголд байгаа бөгөөд тэд англи хэл зааж байна. Түүнчлэн манай хүмүүс эрүүл мэнд, боловсрол, байгаль орчныг хамгаалах салбарт ч

ажиллаж байна. Одоо би АНУ, Монголын хэлхээ харилцаа хэрхэн өргөжиж байгааг тод харуулсан, хэлэх дуртай нэг тоо хэлье. Эдүгээ АНУ-ын Их, Дээд сургуулиудад 10 жилийн өмнөхөөс 20 дахин олон тооны Монголын охид хөвгүүд суралцаж байна.

АНУ-Монголын харилцаа Монголын хувьд шилжилтийн ээдрээтэй энэ цаг үед ч үргэлжлэн хөгжсөөр байна. Улиран ирэх он жилүүдэд ч бүр өсөн бэхжсээр байх болно гэдэгт би эргэлзэхгүй байна. "Гараа сайн бол бариа сайн" гэдэг Монголын зүйр үг байдаг шүү дээ.

Тэр ёсоор ч АНУ, Монголын харилцаа эхний 10 жилдээ урт удаан хугацааны, элэгсэг дотно, үр өгөөжтэй харилцааны эхлэлийг тавилаа.

Манай ард түмнүүдийн цаашдын найрамдал, нөхөрлөлийн төлөө энэ хундагыг дэвшүүлье.